ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/182/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:Tserenkhand@audit.gov.mn<br>Аудитор: Г.Энхдэлгэр<br>Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт
Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
Гурав. Аудитын илрүүлэлт
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 25 № 106

танай ____________ -ны № ______________ -т

ДАРИВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд дөрвөн арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс 790,156.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 65,415.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

**Аудитын гол асуудал**

Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар малчин иргэдээс 5,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авсан байна.

822505000313

**Бусад асуудал**

Төсвийн захирагчийн сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт 73 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, 76.1 хувиар дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 27,016,715.80 | 6,666,181.00 |
| **335** | **Бусад авлага** | 27,016,715.80 | 6,666,181.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 20,350,534.80 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 6,666,181.00 | 6,666,181.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 234,306,638.00 | 251,769,127.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 88,436,288.00 | 105,898,777.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,272,000.00 | 2,060,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 79,566,388.00 | 84,501,388.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,297,900.00 | 19,037,389.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 300,000.00 | 300,000.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 28,601,600.00 | 28,601,600.00 |
| 35600 | Мал амьтад | 117,268,750.00 | 117,268,750.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **260,801,353.80** | **258,435,308.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,473,789,627.78 | 1,555,552,119.62 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,264,684,827.78 | 1,334,067,319.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 648,728,319.96 | 651,948,319.96 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (225,998,122.83) | (262,471,747.47) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 228,321,360.00 | 302,821,360.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (153,842,401.77) | (173,579,346.23) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,700,142.00 | 150,080,603.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (56,199,205.89) | (68,975,844.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,742,350.00 | 44,264,350.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,587,015.47) | (17,679,225.83) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,047,190,278.00 | 1,154,223,278.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (357,845,021.22) | (447,038,573.14) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 454,145.00 | 454,145.00 |
| 39217 | Ном | 20,000.00 | 20,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 209,104,800.00 | 221,484,800.00 |
| 39301 | Програм хангамж | 1,710,000.00 | 1,710,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,710,000.00) | (1,710,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 209,854,800.00 | 222,234,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (750,000.00) | (750,000.00) |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,473,789,627.78** | **1,555,552,119.62** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,735,112,981.58** | **1,813,987,427.62** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 30,161,518.78 | 13,559,489.00 |
| **413** | **Өглөг** | 30,161,518.78 | 13,559,489.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 18,399,818.78 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 11,761,700.00 | 13,559,489.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,761,700.00 | 13,559,489.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **30,161,518.78** | **13,559,489.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,704,951,462.80 | 1,800,427,938.62 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 437,621,320.45 | 437,621,320.45 |
| 51101 | Өмч: - төрийн | 437,621,320.45 | 437,621,320.45 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,068,196,925.49 | 1,163,673,401.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 658,813,115.97 | 1,068,196,925.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 409,383,809.52 | 95,476,475.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 199,133,216.86 | 199,133,216.86 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,704,951,462.80** | **1,800,427,938.62** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,735,112,981.58** | **1,813,987,427.62** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **756,773,743.80** | **837,118,985.80** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 46,962,185.80 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 46,962,185.80 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 740,773,743.80 | 790,156,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 724,741,300.00 | 790,156,800.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 6,300,000.00 | - |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 9,732,443.80 | - |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **506,891,528.00** | **232,643,461.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 506,891,528.00 | 232,643,461.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,174,415.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,174,415.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 443,667,113.00 | 231,143,461.93 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 51,050,000.00 | 1,500,000.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,263,665,271.80** | **1,069,762,447.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **874,631,997.08** | **974,285,971.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 743,485,412.28 | 939,771,283.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 436,969,225.89 | 539,359,344.87 |
| 210101 | Үндсэн цалин | 260,100,567.79 | 305,271,507.87 |
| 210102 | Нэмэгдэл | 172,837,106.19 | 228,578,037.00 |
| 210104 | Урамшуулал | 4,031,551.91 | 5,509,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,186,418.78 | 63,620,181.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,105,318.78 | 41,554,615.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,540,300.00 | 5,827,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,780,600.00 | 2,914,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,293,600.00 | 2,883,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,466,600.00 | 10,440,365.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,467,307.70 | 38,397,869.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,767,307.70 | 8,829,869.15 |
| 210302 | Түлш, халаалт | 26,700,000.00 | 29,568,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,275,990.00 | 19,786,331.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,765,050.00 | 3,184,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,694,140.00 | 12,567,581.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 3,216,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 622,100.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,194,700.00 | 757,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 165,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 165,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,044,000.00 | 16,716,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 12,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,044,000.00 | 4,716,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,547,047.01 | 17,629,610.01 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,470,637.00 | 15,366,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,264,400.00 | 1,241,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 586,210.01 | 586,210.01 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 162,830,422.90 | 243,961,946.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,330,650.00 | 78,040,976.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,000.00 | 1,170,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 140,299,772.90 | 165,272,970.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 131,146,584.80 | 34,514,688.77 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 110,052,634.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 30,702,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 79,291,500.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 59,134.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 21,093,950.80 | 34,514,688.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,093,950.80 | 30,788,483.97 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,726,204.80 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **874,631,997.08** | **974,285,971.91** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **389,033,274.72** | **95,476,475.82** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **756,773,743.80** | **837,118,985.80** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 46,962,185.80 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 46,962,185.80 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 740,773,743.80 | 790,156,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 724,741,300.00 | 790,156,800.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 6,300,000.00 | - |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 9,732,443.80 | - |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **12,174,415.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,174,415.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12,174,415.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,174,415.00 | - |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **768,948,158.80** | **837,118,985.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **748,948,158.80** | **821,748,985.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **617,801,574.00** | **787,234,297.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 434,600,342.29 | 549,044,344.87 |
| 210101 | Үндсэн цалин | 257,731,684.19 | 313,156,507.87 |
| 210102 | Нэмэгдэл | 172,837,106.19 | 229,578,037.00 |
| 210104 | Урамшуулал | 4,031,551.91 | 6,309,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,671,600.00 | 72,335,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,590,500.00 | 49,819,434.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,540,300.00 | 5,902,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,780,600.00 | 2,951,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,293,600.00 | 2,951,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,466,600.00 | 10,710,365.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,467,307.70 | 38,397,869.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,767,307.70 | 8,829,869.15 |
| 210302 | Түлш, халаалт | 26,700,000.00 | 29,568,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,388,240.00 | 26,548,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,407,300.00 | 1,995,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,694,140.00 | 20,000,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 3,216,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 622,100.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 664,700.00 | 1,276,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 429,800.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 429,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,000,000.00 | 5,619,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.00 | 5,619,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,044,000.00 | 16,716,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 12,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,044,000.00 | 4,716,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 24,351,047.01 | 18,424,591.01 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,274,637.00 | 15,861,181.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,264,400.00 | 1,541,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 586,210.01 | 586,210.01 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,849,237.00 | 60,148,442.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,649,237.00 | 58,978,442.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,000.00 | 1,170,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **131,146,584.80** | **34,514,688.77** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 110,052,634.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 30,702,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 79,291,500.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 59,134.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 21,093,950.80 | 34,514,688.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,093,950.80 | 30,788,483.97 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,726,204.80 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)** | **748,948,158.80** | **821,748,985.80** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,000,000.00** | **15,370,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,000,000.00** | **15,370,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,000,000.00 | 15,370,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,000,000.00 | 15,370,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,000,000.00** | **15,370,000.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(20,000,000.00)** | **(15,370,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 437,621,320.45 | 199,133,216.86 | 658,813,115.97 | 1,295,567,653.28 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **437,621,320.45** | **199,133,216.86** | **658,813,115.97** | 1,295,567,653.28 |
| C09 | Тайлант үеийн үр дүн | - | - | 409,383,809.52 | 409,383,809.52 |
| C10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| C11 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **437,621,320.45** | **199,133,216.86** | **1,068,196,925.49** | 1,704,951,462.80 |
| C12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **437,621,320.45** | **199,133,216.86** | **1,068,196,925.49** | 1,704,951,462.80 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 95,476,475.82 | 95,476,475.82 |
| C20 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **437,621,320.45** | **199,133,216.86** | **1,163,673,401.31** | 1,800,427,938.62 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| дийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Цэвэр гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **805,220,700.00** | **759,368,316.03** | **45,852,383.97** | **94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 805,220,700.00 | 759,368,316.03 | 45,852,383.97 | **94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 805,220,700.00 | 759,368,316.03 | 45,852,383.97 | **94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 556,401,400.00 | 549,044,344.87 | 7,357,055.13 | **99** |
| 210101 | Үндсэн цалин | 320,235,000.00 | 313,156,507.87 | 7,078,492.13 | **98** |
| 210102 | Нэмэгдэл | 226,166,400.00 | 229,578,037.00 | (3,411,637.00) | **102** |
| 210104 | Урамшуулал | 10,000,000.00 | 6,309,800.00 | 3,690,200.00 | **63** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 72,335,000.00 | 72,335,000.00 | 0.00 | **100** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,724,700.00 | 49,819,434.55 | (1,094,734.55) | **102** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,902,600.00 | 5,902,600.00 | - | **100** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,951,300.00 | 2,951,300.00 | - | **100** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,951,300.00 | 2,951,300.00 | - | **100** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,805,100.00 | 10,710,365.45 | 1,094,734.55 | **91** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,068,000.00 | 38,397,869.15 | 2,670,130.85 | **93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,500,000.00 | 8,829,869.15 | (329,869.15) | **104** |
| 210302 | Түлш, халаалт | 29,568,000.00 | 29,568,000.00 | - | **100** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | - | 3,000,000.00 | **0** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,369,400.00 | 16,548,550.00 | 2,820,850.00 | **85** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,000,000.00 | 1,995,300.00 | 1,004,700.00 | **67** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,000,000.00 | 10,000,200.00 | (200.00) | **100** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,000,000.00 | 3,216,750.00 | 783,250.00 | **80** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 60,000.00 | 20,000.00 | **75** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,289,400.00 | 1,276,300.00 | 1,013,100.00 | **56** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,650,900.00 | 20,989,500.00 | 9,661,400.00 | **68** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,000,000.00 | 15,370,000.00 | 1,630,000.00 | **90** |
| 210604 | Урсгал засвар | 13,650,900.00 | 5,619,500.00 | 8,031,400.00 | **41** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,570,000.00 | 16,716,000.00 | 854,000.00 | **95** |
| 210701 | Гадаад албан томилолт | 12,000,000.00 | 12,000,000.00 | - | **100** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,570,000.00 | 4,716,000.00 | 854,000.00 | **85** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,850,000.00 | 5,486,910.01 | 5,363,089.99 | **51** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,500,000.00 | 2,923,500.00 | 2,576,500.00 | **53** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 403,200.00 | 296,800.00 | **58** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | - | 500,000.00 | **0** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400,000.00 | - | 400,000.00 | **0** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 33,000.00 | 217,000.00 | **13** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,500,000.00 | 1,541,000.00 | 959,000.00 | **62** |
| 210807 | Газрын төлбөр | 1,000,000.00 | 586,210.01 | 413,789.99 | **59** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,976,000.00 | 39,850,142.00 | 17,125,858.00 | **70** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,476,000.00 | 38,680,142.00 | 15,795,858.00 | **71** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 1,170,000.00 | 1,330,000.00 | **47** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **805,220,700.00** | **759,368,316.03** | **45,852,383.97** | **94** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 805,220,700.00 | 759,368,316.03 | 45,852,383.97 | **94** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 805,220,700.00 | 759,368,316.03 | 45,852,383.97 | **94** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | | | |

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Батлагдсан төлөвлөгөө** |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **46,962,185.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 46,962,185.80 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 43,235,981.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,937,681.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,937,681.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,298,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,298,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,726,204.80 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,726,204.80 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,726,204.80 |

| | | |
|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **46,962,185.80** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,962,185.80 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46,962,185.80 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар 45,542.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 45,542.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Залруулагдаагүй 24,463.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба материаллаг 9,093.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 24,463.0 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрч 3 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаадлагыг хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02/101, 07/101, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/13, 03/13, 04/13, 05/13 дугаартай зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/77, 02/77, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/08 дугаартай төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, төсвийг үр ашиггүй зарцуулж албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Эрдэнэбилэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Нэг. Хууль тогтоомжтой холбоотой**

Цахим дэлгүүрээс 15,370.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, компьютерийг худалдан аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмж, барааг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

**Хоёр: Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой**

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон эдийн засгийн ангилал зөрчин төсвийн хөрөнгөөр 4,093.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгал, шагналын зүйл авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр "Ангилал шинэчлэн батлах тухай" тушаалтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх.

**Гурав: Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар малчин иргэдээс 5,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:", 25.5-т "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хандив тусламжийн орлогыг зөвхөн хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр хүлээн авч, данс бүртгэлд тусган зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын Тамгын газар | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 45,542.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 45,542.7 | 1 | 45,542.7 | - | - | 1 | 45,542.7 | - | - | - | - |
| **Дүн** | | **1** | **45,542.7** | **1** | **45,542.7** | **-** | **-** | **1** | **45,542.7** | **-** | **-** | **-** | **-** |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн: Тоо | Нийт алдаа, зөрчлийн дүн: Дүн | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг | Төрийн хэмнэлтийн тухай хууль болон эдийн засгийн ангилал зөрчин төсвийн хөрөнгөөр 4,093.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгал, шагналын зүйл авч зарцуулсан. | 1 | 4,093.0 | - | - | | | 1 | 4,093.0 | | |
| | Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтын дансаар малчин иргэдээс | 1 | 5,000.0 | - | - | | | 1 | 5,000.0 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| даргын Тамгын газар | 5,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авсан байна. | | | | | | | | | | |
| | Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02/101, 07/101, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/13, 03/13, 04/13, 05/13 дугаартай зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/77, 02/77, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/08 дугаартай төлбөрийн актыг барагдуулаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | | | | |
| | Цахим дэлгүүрээс 15,370.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, комьпютер худалдан аваагүй. | 1 | 15,370.0 | - | - | - | - | 1 | 15,370.0 | | |
| **Нийт** | | **4** | **24,463.0** | **-** | **-** | **1** | **-** | **3** | **24,463.0** | | |